

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/321/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70272248 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн "Релаэнс секюритиз Аудит" ХХК

Утас: 99813174 Цахим хаяг: rsamongolia@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан.....
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/190
танай _____-ны № _____-Т

ТӨВ АЙМГИЙН БАЯНЖАРГАЛАН СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 9 ЖИЛИЙН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ж.ЗОЛЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын 9 жилийн сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно. Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 хөтөлбөр 12 арга хэмжээтэй боловсруулан төлөвлөж, 87.6 хувиар хэрэгжүүлсэн байна

Аудитын гол асуудал

Тухайн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020138

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12-р сарын 31ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	151,646,313.68	166,883,154.70
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГ	86,133,877.15	97,612,459.47
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	86,133,877.15	97,612,459.47
9	Төгрөг	86,133,877.15	97,612,459.47
10	Төрийн сангийн харилцах	86,133,877.15	97,612,459.47
27	АВЛАГА	-	85,250.00
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	85,250.00
35	Байгууллагаас авах авлага	(131,588.00)	(131,588.00)
36	Хувь хүмүүсээс авах авлага	131,588.00	131,588.00
60	БАРАА МАТЕРИАЛ	65,512,436.53	69,185,445.23
61	Түүхий эд материал	100,094.00	100,094.00
63	Эм боох материал	100,094.00	100,094.00
66	Хангамжийн материал	65,412,342.53	69,085,351.23
67	Бичиг хэргийн материал	7,427,286.26	9,723,086.26
68	Аж ахуйн материал	34,123,562.00	34,339,342.00
72	Хүнсний материал	4,284,596.72	2,684,682.72
73	Бусад хангамжийн материал	19,576,897.55	22,338,240.25
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,433,481,401.52	1,457,377,777.62
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,433,481,401.52	1,457,377,777.62
108	Биет хөрөнгө	1,386,099,401.52	1,409,995,777.62
109	Барилга, байгууламж	1,467,993,750.51	1,467,993,750.51
110	Хуримтлагдсан элэгдэл	(170,234,964.58)	(216,515,273.38)
113	Машин, тоног төхөөрөмж	138,644,873.86	168,560,973.21
114	Хуримтлагдсан элэгдэл	(85,059,160.78)	(52,819,044.97)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,302,596.00	88,442,412.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(59,912,123.48)	(51,031,469.74)
125	Номын фонд	5,364,429.99	5,364,429.99
126	Биет бус хөрөнгө	47,382,000.00	47,382,000.00
127	Програм хангамж	535,000.00	535,000.00
128	Хасагдуулга	(535,000.00)	(535,000.00)
129	Бусад биет бус хөрөнгө	47,382,000.00	47,382,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,585,127,715.20	1,624,260,932.32
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,585,127,715.20	1,624,260,932.32
215	Засгийн газрын хувь оролцоо	1,585,127,715.20	1,624,260,932.32
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	476,568,508.51	476,568,508.51
217	Өмч: -Төрийн өмч	476,568,508.51	476,568,508.51
223	Хуримтлагдсан үр дүн	601,888,989.50	641,363,667.53
224	Өмнөх үеийн үр дүн	601,888,989.50	602,230,450.41
225	Тайлант үеийн үр дүн	-	39,133,217.12
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	506,670,217.19	506,328,756.28
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,585,127,715.20	1,624,260,932.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,429,613,466.15	880,998,370.30
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,675,076,366.15	193,592,570.30
77	Нийтлэг татварын бус орлого	1,549,444,366.15	81,703,970.30
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,549,444,366.15	80,408,922.30
83	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	471,500.00	-
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого (Үндсэн хөрөнгө)	1,485,165,674.97	77,397,579.60
87	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого (бараа материал)	63,807,191.18	3,011,342.70
92	Бусад орлого	-	1,295,048.00
102	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	125,632,000.00	111,888,600.00
105	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох	125,632,000.00	111,888,600.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	754,537,100.00	687,405,800.00
122	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,982,600.00	-
126	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	118,982,600.00	-
131	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт \орон нутгийн төсвөөс санхүүжих \	635,554,500.00	687,405,800.00
138	Төсвийн захирагчдаас	635,554,500.00	687,405,800.00
148	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	844,485,750.95	841,260,153.18
149	УРСГАЛ ЗАРДАЛ	844,485,750.95	841,260,153.18
150	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	694,944,565.79	808,331,518.03
151	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	424,372,294.53	493,824,478.90
152	Цалин	313,835,025.17	367,471,272.25
153	Нэмэгдэл цалин	90,665,836.55	107,478,690.14
155	Урамшуулал	19,871,432.81	18,874,516.51
158	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	52,805,633.05	60,782,340.78
159	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,484,307.77	42,092,578.04
160	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,251,218.48	4,996,871.47
161	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,400,974.67	3,955,697.23
162	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	790,759.32	915,925.14
163	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,878,372.81	8,821,268.90
165	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,959,830.11	107,615,464.85
166	Гэрэл цахилгааны зардал	4,211,030.11	5,829,008.35
167	Түлш, халаалтын зардал	88,652,800.00	101,786,456.50
168	Цэвэр, бохир усны зардал	96,000.00	-
171	Хангамж, бараа материалын зардал	5,883,975.65	1,933,820.00
172	Бичиг хэргийн материал	185,000.00	-
179	Бараа материал актасны зардал	5,698,975.65	1,933,820.00
182	Нормативт зардал	30,948,340.00	48,192,208.00
184	Хоол	30,948,340.00	48,192,208.00
186	Эд хогшил, урсгал засварын зардал	600,000.00	-
190	Урсгал засвар	600,000.00	-
195	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр х	3,620,200.00	3,553,200.00
196	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,144,400.00
201	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,620,200.00	2,408,800.00
210	Бараа үйлчилгээний бусад зардал	83,754,292.45	92,430,005.50
211	Бараа үйлчилгээний бусад зардал	15,570,069.00	13,922,602.00
212	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	3,826,950.00	7,016,200.00
213	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	64,357,273.45	71,491,203.50
225	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,541,185.16	32,928,635.15
229	Бусад урсгал шилжүүлэг	148,439,600.00	29,655,500.00
233	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,007,000.00	29,655,500.00
235	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,164,800.00	-
236	Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,267,800.00	-
238	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,101,585.16	3,273,135.15
241	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,101,585.16	3,273,135.15
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	1,585,127,715.20	39,738,217.12
277	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	605,000.00
278	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	605,000.00
288	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(605,000.00)
289	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	1,585,127,715.20	39,133,217.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	881,834,530.00	800,589,448.00
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	762,851,930.00	800,589,448.00
78	Нийтлэг татварын бус орлого	1,665,430.00	1,295,048.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,665,430.00	-
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,193,930.00	-
84	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	471,500.00	-
92	Бусад орлого	-	1,295,048.00
103	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	761,186,500.00	799,294,400.00
105	урсгал ?йл ажиллагааны санх?үжилт\орон нутгийн төсөв\	635,554,500.00	687,405,800.00
106	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	125,632,000.00	111,888,600.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	118,982,600.00	-
121	Нэмэлт санхүүжилтийн орлого	118,982,600.00	-
125	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	118,982,600.00	-
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	795,700,652.85	770,515,865.68
148	УРСГАЛ ЗАРДАЛ	795,700,652.85	770,515,865.68
149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	651,887,767.69	734,002,630.53
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	424,238,073.38	494,050,502.23
151	Үндсэн цалин	313,401,403.00	368,343,502.26
152	Нэмэгдэл	90,965,237.62	107,317,243.26
154	Үр дүнгийн урамшуулал	19,871,432.76	18,389,756.71
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	52,939,854.20	60,963,781.45
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,813,116.86	42,016,025.20
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	4,195,266.21	4,995,311.80
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,356,272.86	3,954,449.50
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	779,508.87	915,613.20
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,795,689.40	9,082,381.75
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	92,959,830.11	107,615,464.85
165	Гэрэл цахилгааны зардал	4,211,030.11	5,829,008.35
166	Түлш, халаалтын зардал	88,652,800.00	101,786,456.50
167	Цэвэр, бохир усны зардал	96,000.00	-
181	Нормативт зардал	41,039,110.00	43,804,694.00
183	Хоол, хүнс	41,039,110.00	43,804,694.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	1,783,450.00	1,000,000.00
189	Урсгал засвар	1,783,450.00	1,000,000.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,323,300.00	5,074,200.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	-	1,144,400.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,323,300.00	3,929,800.00
208	Бараа үйлчилгээний бусад зардал	34,604,150.00	21,493,988.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	27,479,750.00	14,892,688.00
210	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	7,124,400.00	6,601,300.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	143,812,885.16	36,513,235.15
225	Бусад урсгал шилжүүлэг	142,711,300.00	33,240,100.00
229	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	26,278,700.00	33,240,100.00

231	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	91,164,800.00	-
232	Хөдөө орон нутагт тогвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	25,267,800.00	-
244	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,101,585.16	3,273,135.15
248	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,101,585.16	3,273,135.15
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	86,133,877.15	30,073,582.32
261	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	18,595,000.00
262	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	18,595,000.00
263	Дотоод эх үүсвэрээр	-	18,595,000.00
271	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал /Г	-	18,595,000.00
278	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-	(18,595,000.00)
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	86,133,877.15	11,478,582.32
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	86,133,877.15
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	86,133,877.15	97,612,459.47

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	476,568,508.51	506,670,217.19	60,188,898.50	1,585,127,715.20
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	476,568,508.51	506,670,217.19	60,188,898.50	1,585,127,715.20
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			341,460.91	341,460.91
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	476,568,508.51	506,670,217.19	602,230,450.41	1,585,469,176.11
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өөрчлөлт	0	(341,460.91)	0	(341,460.91)
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			39,133,217.12	39,133,217.12
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	476,568,508.51	506,328,756.28	641,363,667.53	1,624,260,932.32

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	86,133,877.15	(86,133,877.15)	0.0
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	773,078,600.00	677,222,265.68	95856334.3	87.6
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	773,078,600.00	677,222,265.68	95856334.3	87.6
4	Бараа, үйлчилгээний зардал	734,523,500.00	643,982,165.68	90541334.3	87.7
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,460,100.00	494,050,502.23	75409597.8	86.8
6	Үндсэн цалин	394,527,600.00	368,343,502.26	26184097.7	93.4
7	Нэмэгдэл	156,133,900.00	107,317,243.26	48816656.7	68.7
9	Урамшуулал	18,798,600.00	18,389,756.71	408843.3	97.8

11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	71,182,600.00	60,963,781.45	10218818.6	85.6
12	Тэтгэврийн даатгал	48,404,000.00	42,016,025.20	6387974.8	86.8
13	Тэтгэмжийн даатгал	5,694,700.00	4,995,311.80	699388.2	87.7
14	ҮОМШӨ ний даатгал	4,555,700.00	3,954,449.50	601250.5	86.8
15	Ажилгүйдлийн даатгал	1,139,000.00	915,613.20	223386.8	80.4
16	Эрүүл мэндийн даатгал	11,389,200.00	9,082,381.75	2306818.3	79.7
30	Нормативт зардал	48,850,500.00	43,804,694.00	5045806.0	89.7
32	Хоол, хүнс	48,850,500.00	43,804,694.00	5045806.0	89.7
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,	4,400,900.00	5,074,200.00	-673300.0	115.3
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,144,400.00	-1144400.0	0.0
49	Мэдээллийн технологийн зардал	4,400,900.00	3,929,800.00	471100.0	89.3
53	Бараа үйлчилгээний бусад зардал	40,629,400.00	40,088,988.00	540412.0	98.7
54	Бараа үйлчилгээний бусад зардал	34,028,100.00	33,487,688.00	540412.0	98.4
55	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,601,300.00	6,601,300.00	0.0	100.0
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,555,100.00	33,240,100.00	5315000.0	86.2
70	Бусад урсгал шилжүүлэг	38,555,100.00	33,240,100.00	5315000.0	86.2
74	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, дэмжлэг	38,555,100.00	33,240,100.00	5315000.0	86.2
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	772,131,100.00	687,405,800.00	84725300.0	89.0
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛА	772,131,100.00	687,405,800.00	84725300.0	89.0
114	Төсвөөс санхүүжих	772,131,100.00	687,405,800.00	84725300.0	89.0
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	-	86,133,877.15	-86133877.2	0.0
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн	-	97,612,459.47	-97612459.5	0.0
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	34.00	33.00	1.0	97.1
134	Удирдах ажилтан	1.00	1.00	0.0	100.0
135	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00	0.0	100.0
136	Үйлчлэх ажилтан	15.00	14.00	1.0	93.3

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай, бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус байгууллага нь Боловсрол шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 оныг "Сургуулийн менежментийг сайжруулах" жил болгон зарлаж, дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 1 зорилт, 12 арга хэмжээтэйгээр боловсруулан хэрэгжүүлж, төлөвлөгөөг 87,6 хувиар биелүүлж ажилласан байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 31 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил гүйлгээ худалдан авах тухай хууль,
- Шилэн дансны тухай хууль,

- Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа эрүүл мэндийн яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэн хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэх үйл ажиллагаа явуулж, үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжууд мөн Сангийн яам болон харьяа яамнаас гаргасан тушаал, заавар журам шийдвэрүүдийг мөрдөж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

2023 он 11 сарын 7 өдөр аймгийн Засаг даргын нэрэмжит үзлэг шалгалт хамрагдаж, 93.0 хувьтай үнэлэгдсэн.

2023 оны 11 дүгээр сарын 1 өдөр сумын хяналт шалгалт үнэлгээний хорооны шалгалтаар 87,0 хувьтай үнэлэгдсэн.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 39,133.3 мянган төгрөгөөр буюу 2,4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	86,133.8	97,612.5	11478.6
Авлага		85.2	85.2
Урьдчилгаа			
Бараа материал	65,512.4	69,185.4	3,673.0
Үндсэн хөрөнгө	1,433,481.4	1,457,377.8	23,896.3
Нийт хөрөнгө	1,585,127.6	1,624,260.9	39,133.3
Өр төлбөр			
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,585,127.7	1,624,260.9	39,133.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,585,127.7	1,624,260.9	39,133.3

Дээрх хүснэгтээс харахад 2023 оны эцэст мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 11,478.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь /орон тоо хэмнэж ажилласан/ үндсэн цалин, нэмэгдэл зэргийг хэмнэснээс мөнгөн хөрөнгө данс өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 85.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Нийгмийн даатгалын шимтгэл илүү шилжүүлсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 3,673.0 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд улсад 3-р түвшинд үнэлэгдэн урамшуулал авсан нь бичиг хэргийн материалын үлдэгдэл нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө данс 23,896.3 мянган төгрөгөөр өссөн нь: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 18,595.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, хандиваар 5,301.3 мянган төгрөгийн тавилга хэрэгсэл тус тус орлого авч бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 773,078.6 мянган төгрөг, Орон нутгийн төсвөөс 111,888.6 мянган төгрөг нийт зарлагыг 884,967.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 884,967.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 773,078.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 111,888.6 мянган төгрөгийг орон нутгийн санхүүжилтээр Төсвийг нийт 884,967.2 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 677,222.2 мянган төгрөг буюу 87,6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 95,856.3 мянган төгрөгөөр, үүнээс үндсэн цалин хөлс болон нэмэгдэл цалинг 75,409,6 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын зардлыг

10,218,8 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 5,045,8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

					/мянган төгрөгөөр/	
д/д	71802-Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	80226-Байр ашиглалтын үйлчилгээ	1,760.4	1,760.4		100,0%	
2	80312-Сургалт семинар	1,020,6	512,5	508,4	50,2%	
3	81605-Эрүүл мэндийг дэмжих	1,760,4	1,760,4		100,0%	
4	81801-Үдийн цай хөтөлбөр	38,555,1	33,240.1	5,315,0	86,2%	
5	81806- Дотуур байрны үйлчилгээ	28,389.7	24,831.2	3,558.4	87.4%	
6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	67,411,2	55,270,1	12,141,1	100,0%	
7	81823- Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	3,960,8	3,905,8	55,0	98,6%	
8	81827- Бичиг үсгийн боловсрол олгох	3,220,0	536,3	2,683,7	16,7%	
9	81834- Боловсролын стандарт	495,656,3	431,946,7	53,709,6	87,1%	
10	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	133,005,5	118,285,5	14,719,9	88,9%	
11	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	150,7	150.6	0,1	100,0%	
12	81848- Сурах бичгийн түрээс		1,144,4	1,144,4		

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэмэлт санхүүжилтийн төсөв байхгүй.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

							/мянган төгрөгөөр/	
№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан		
1	71802-80226	2023-12-31	Байр ашиглалтын үйлчилгээ	100,0%	1,760,4	1,760,4		
2	71802-80312	2023-12-31	Сургалт семинар	50,2%	1,020,6	512,5		
3	71802-	2023-12-31	Эрүүл мэндийг	100,0%	1,760,4	1,760,4		

	81605		дэмжих			
4	71802-81801	2023-12-31	Үдийн цай хөтөлбөр	86,2%	38,555,1	33,240,1
5	71802-81806	2023-12-31	Дотуур байрны үйлчилгээ	96.8%	67,411,2	55,270,1
6	71802-81816	2023-12-31	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	100,0%	18,709,8	18,709,8
7	71802-81823	2023-12-31	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	98,6%	3,960,8	3,905,8
8	71802-81827	2023-12-31	Бичиг үсгийн боловсрол олгох	19,0%	3,220,0	536,3
9	71802-81834	2023-12-31	Боловсролын стандарт	87,1%	495,656,3	431,946,7
10	71802-81835	2023-12-31	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	88.9%	133,005,5	118,285,5
11	71802-81844	2023-12-31	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	100,0%	150.6	150.6
12	71802-81848	2023-12-31	Сурах бичгийн түрээс			1,144,4

Бичиг үсгийн боловсрол олгох арга хэмжээ нь хангалтгүй болсон нь сургалтад хамрагдах ирц муугаас, сурах бичгийн түрээс арга хэмжээ дутуу хэрэгжсэн нь сурах бичиг түрээслэх сурагчид бага байсан нь тус тус нөлөөлсөн байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна. Сумын тамгын газраас тендер шалгаруулж, Баясгалант ХХК-иас шууд худалдан авалт хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах ажиллагчидтай холбоотой авлагыг барагдуулах, дансны үлдэгдлийг улирал, жилийн санхүүгийн эцэст баталгаажуулж байхтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн аудитор С.Дашдондог, аудитор Б.Мягмар нар гүйцэтгэж, хяналтыг “Релаэнс секюритиз аудит” ХХК-ийн захирал, Ж.Цэцэгмаа, Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт, аудитын

менежер О.Амаржаргал, дарга, Тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 09/03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн, нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 200,000,0 мянган төгрөгөөс 2.0 хувиар буюу 4,000.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,200.0 мянган төгрөгөөр тооцлоо. Аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулах буюу хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий сургууль нь 2023 онд батлагдсан төсвийг үр бүтээлтэй хэрэгжүүлэн ажилласан байна. Тайлант оны төсвийг 96,280.7 мянган төгрөгөөр хэмнэсэн. Үүнд: Үндсэн цалин болон нэмэгдэл 75,409.6 мянган төгрөг, цалин хөлстэй холбоотой даатгалын зардлыг 10,218.8 мянган төгрөг, нормативт зардлыг 5,045.8 мянган төгрөгөөр тус тус төлөвлөгөөнөөс хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хөтлөлтийг шалгахад 2023 онд Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь 159 мэдээллийг шилэн дансанд байршуулахаас 133 мэдээллийг байршуулж 26 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан. Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв бодитой иж бүрэн байх”, 4.1.3-д “тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, 6.4.4-д “Таван саяаас дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа ажил гүйлгээ”, МУЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.3 “өөрийн хянах цэсийн мэдээллийг байнга хянах” заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Цаашид Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэхдээ нэг ч мэдээлэл хоцруулахгүй байхыг анхааруулан зөвлөмж өглөө.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувь биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	4	12,340.1	4	12,340.1	100%
Албан шаардлага	1		1		100%
Зөвлөмж	3	440.7	3	440.7	100%
Нийт дүн	8	12,780.8		12,780.8	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Баянжаргалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,726.2 мянган төгрөгийн 2 зөрчил илэрснээс 1,200.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 526.2 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

5.2 Албан шаардлага

1. Зардлын данстай холбоотой

Илрүүлэлт:

2023 оны хүнсний материалын зарцуулалтын тайланг шалгахад хүүхдийн хоолны жишиг орц нормыг дагаж мөрдөөгүй 1,200.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь Боловсрол шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн А/166, А/556, 222 тоот хамтарсан тушаалын заалт, санхүүгийн тайлангийн “Тохиолдсон байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.6-д “Эрх бүхий этгээдээс тогтоосон норм нормативыг хэтрүүлэн зарцуулсан” гэж заасныг үндэслэн дээрх дутагдлыг дахин гаргахгүй байх албан шаардлага өглөө.

5.3 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Цалин хөлсний тооцооллыг шалгахад тооцоолсон цалин, олговол зохих цалингийн дүн зөрүүтэй 526.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ. Энэ нь НББ-н тухай хуулийн 20,2,3–т/Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргах”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д” Төсвийг зохистой удирдаж, авлага өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалт, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Цаашид цалингийн программд өгөгдлийг зөв оруулж хэвших.

Дээрх албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Хүнсний материалын орц нормыг хууль журмын дагуу тооцоогүй	1	1,200,0			1	1200,0							
Цалингийн программд өгөгдлийг зөв оруулж, хянаж байх	1	526,2					1	526,2					
Дүн	2	1,726,2			1	1,200,0	1	526,2					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд байршуулах 159 мэдээллээс 133 мэдээллийг байршуулж 26 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан	1							1
Дүн	1							1
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн								

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn